БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/47/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon @gmail.com
Аудитор:: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.. **Error! Bookmark not defined.**
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 10
4.1 Ерөнхий зүйл ........ 16
4.2 Материаллаг байдал ........ 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/48

танай___________-ны № ____________ -т

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.ЗОЛЗАЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заварын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.

Тус онд 17,559.2 мянган төгрөгийн өглөг, авлага үүсгэж, 539,205.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 ”батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.2. “Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл суурьаар бүртгэж, тайлагнана”, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга зөрчин үр дүнгийн урамшууллыг олгосон, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5020199

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 12 арга хэмжээний зардалд 1,319,340.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,248,516.4 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 625.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 74,216.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах,нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар цахим хэрэглээний зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, үдийн хоолны материалын үлдэгдэл ихтэй байгаа зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс бага байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90.0 хувьтай тайлагнаж дээд шатны байгууллагаас 84 хувьтай дүгнэсэн байна.

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **217,182,504.16** | **216,995,311.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 96,415,449.97 | 74,216,560.66 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 96,415,449.97 | 74,216,560.66 |
| **3121** | **Төгрөг** | 96,415,449.97 | 74,216,560.66 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 96,415,449.97 | 74,216,560.66 |
| **33** | **АВЛАГА** | 2,327,792.00 | 10,030,696.26 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 2,327,792.00 | 10,030,696.26 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 5,150,000.00 | 00.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 5,150,000.00 | 00.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 5,150,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 113,289,262.19 | 132,748,054.19 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,633,900.00 | 6,305,857.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,868,400.00 | 3,540,357.50 |
| 35130 | Эм боох материал | 2,765,500.00 | 2,765,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 108,655,362.19 | 126,442,196.69 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,359,217.00 | 5,350,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 102,501,171.19 | 116,290,588.69 |
| 35460 | Хүнсний материал | 457,234.00 | 1,009,258.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,337,740.00 | 3,791,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,960,456,596.06** | **2,509,611,569.28** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,960,456,596.06 | 2,509,611,569.28 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,918,948,096.06 | 2,468,185,569.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,066,043,331.00 | 2,428,713,222.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -300,287,755.12 | -244,302,573.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 274,501,828.93 | 382,360,388.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -161,902,716.88 | -180,295,780.67 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 105,211,221.96 | 153,051,221.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -74,126,211.83 | -80,849,307.02 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 39217 | Ном | 6,508,398.00 | 6,508,398.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 41,508,500.00 | 41,426,000.00 |
| 39301 | Програм хангамж | 930,000.00 | 930,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -847,500.00 | -930,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,426,000.00 | 41,426,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,177,639,100.22** | **2,726,606,880.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **90,000.00** | **7,528,616.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 90,000.00 | 7,528,616.00 |
| **413** | **Өглөг** | 90,000.00 | 7,438,616.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 7,348,616.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 90,000.00 | 90,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 90,000.00 | 90,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,177,549,100.22** | **2,719,168,264.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,177,549,100.22 | 2,719,168,264.39 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 364,824,419.85 | 364,824,419.85 |
| 51101 | Өмч: - төрийн | 364,824,419.85 | 364,824,419.85 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,094,959,363.95 | 1,655,428,978.12 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,094,959,363.95 | 1,113,809,813.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 541,619,164.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 717,765,316.42 | 698,914,866.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,177,639,100.22** | **2,726,606,880.39** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,649,845,225.50** | **1,864,082,419.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **583,056,325.50** | **642,337,719.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 583,056,325.50 | 642,337,719.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 583,056,325.50 | 4,880,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,410,439.00 | 4,810,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 70,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 576,645,886.50 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй Үндсэн хөрөнгө | | 629432251.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй Бараа материал | | 8024668.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,066,788,900.00** | **1,221,744,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 927,386,900.00 | 1,099,304,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 927,386,900.00 | 1,099,304,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 139,402,000.00 | 122,440,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 139,402,000.00 | 122,440,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,053,938,308.40** | **1,309,959,729.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,053,938,308.40** | **1,309,959,729.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,001,800,178.40 | 1,274,475,542.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 643,833,499.56 | 821,110,193.81 |
| 210101 | Үндсэн цалин | 462,204,790.65 | 509,608,387.17 |
| 210102 | Нэмэгдэл | 146,434,772.52 | 266,815,516.68 |
| 210104 | Урамшуулал | 10,850,803.39 | 44,686,289.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,343,133.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,335,678.47 | 99,902,815.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,543,199.03 | 68,873,121.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,436,021.29 | 8,267,648.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,975,342.50 | 6,609,718.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,107,032.72 | 1,529,502.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,274,082.93 | 14,622,824.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,491,134.00 | 117,728,476.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,176,294.00 | 7,460,695.51 |
| 210302 | Түлш, халаалт | 89,834,840.00 | 108,467,880.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,480,000.00 | 1,799,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,668,544.26 | 343,400.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 343,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 316,470.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 193,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,159,074.26 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,435,666.00 | 73,371,576.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,437,800.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,997,866.00 | 73,371,576.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 5,292,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 5,292,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 252,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 252,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,640,407.00 | 5,860,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,493,907.00 | 1,060,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,146,500.00 | 4,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 116,143,249.11 | 142,010,966.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,954,075.90 | 24,568,954.15 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,308,383.00 | 8,229,167.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,880,790.21 | 109,212,845.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 52,138,130.00 | 35,484,187.37 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,606,450.00 | 34,858,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,606,450.00 | 21,116,960.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 13,741,740.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,531,680.00 | 625,487.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,531,680.00 | 625,487.37 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **595,906,917.10** | **554,122,689.50** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 12,503,525.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 10,912,432.33 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 1,591,093.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -12,503,525.33 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **595,906,917.10** | **541,619,164.17** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,073,199,339.00** | **1,226,625,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,410,439.00** | **4,880,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,410,439.00 | 4,880,800.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,410,439.00 | 4,880,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,410,439.00 | 4,810,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,066,788,900.00** | **1,221,744,700.00** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 927,386,900.00 | 1,099,304,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 927,386,900.00 | 1,099,304,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 139,402,000.00 | 122,440,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 139,402,000.00 | 122,440,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **976,783,889.03** | **1,208,976,389.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **976,783,889.03** | **1,208,976,389.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **925,894,339.03** | **1,151,673,941.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 648,983,499.56 | 820,536,693.81 |
| 210101 | Үндсэн цалин | 448,438,633.26 | 509,608,387.17 |
| 210102 | Нэмэгдэл | 162,749,442.52 | 266,815,516.68 |
| 210104 | Урамшуулал | 10,850,803.78 | 44,112,789.96 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 26,944,620.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,335,678.47 | 102,140,931.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,437,482.96 | 68,238,931.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,507,021.29 | 8,477,328.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,975,342.50 | 6,762,209.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,123,519.94 | 1,692,619.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,292,311.78 | 16,969,841.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,491,134.00 | 116,814,912.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,176,294.00 | 6,547,131.97 |
| 210302 | Түлш, халаалт | 89,834,840.00 | 108,467,880.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,480,000.00 | 1,799,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 193,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 193,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,982,900.00 | 57,521,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,982,900.00 | 57,521,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 995,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 995,000.00 | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,417,007.00 | 5,887,288.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,531,507.00 | 1,060,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,885,500.00 | 4,826,488.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55,496,120.00 | 43,772,366.15 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,793,550.00 | 34,134,666.15 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,702,570.00 | 9,637,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,889,550.00** | **57,302,447.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,357,870.00 | 56,676,960.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,357,870.00 | 39,972,870.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 16,704,090.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,531,680.00 | 625,487.37 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,531,680.00 | 625,487.37 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **96,415,449.97** | **17,649,110.69** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **39,848,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **39,848,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 39,848,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 39,848,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-39,848,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 96,415,449.97 | -22,198,889.31 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 96,415,449.97 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 96,415,449.97 | 74,216,560.66 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **364,824,419.85** | **717,765,316.42** | **1,094,959,363.95** | 2,177,549,100.22 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **364,824,419.85** | **717,765,316.42** | **1,094,959,363.95** | 2,177,549,100.22 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 18,850,450.00 | 18,850,450.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **364,824,419.85** | **717,765,316.42** | **1,113,809,813.95** | 2,196,399,550.22 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -18,850,450.00 | 00.00 | -18,850,450.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 541,619,164.17 | 541,619,164.17 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **364,824,419.85** | **698,914,866.42** | **1,655,428,978.12** | 2,719,168,264.39 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,319,340,000.0 | 1,248,516,437.9 | 70,823,562.1 | 94.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,319,340,000.0 | 1,248,516,437.9 | 70,823,562.1 | 94.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,135,111,000.0 | 1,191,839,477.9 | -56,728,477.9 | 105.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 876,379,200.0 | 821,110,193.8 | 55,269,006.2 | 93.7 |
| 210101 | Үндсэн цалин | 593,814,000.0 | 509,608,387.2 | 84,205,612.8 | 85.8 |
| 210102 | Нэмэгдэл | 242,477,000.0 | 266,815,516.7 | -24,338,516.7 | 110.0 |
| 210104 | Урамшуулал | 40,088,200.0 | 44,686,290.0 | -4,598,090.0 | 111.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 109,547,600.0 | 102,380,931.4 | 7,166,668.7 | 93.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,492,400.0 | 68,458,931.9 | 6,033,468.1 | 91.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,763,800.0 | 8,477,328.7 | 286,471.3 | 96.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,011,100.0 | 6,782,209.9 | 228,890.1 | 96.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,752,700.0 | 1,692,619.8 | 60,080.2 | 96.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,527,600.0 | 16,969,841.0 | 557,759.0 | 96.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 117,440,400.0 | 116,814,912.6 | 625,487.4 | 99.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,172,500.0 | 6,547,132.0 | 625,368.0 | 91.3 |
| 210302 | Түлш, халаалт | 108,467,900.0 | 108,467,880.7 | 19.3 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.0 | 1,799,900.0 | 100.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,061,600.0 | 57,521,750.0 | 5,539,850.0 | 91.2 |
| 210502 | Хоол, хүнс | 63,061,600.0 | 57,521,750.0 | 5,539,850.0 | 91.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.0 | 5,000,000.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.0 | 5,000,000.0 | 0.0 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,232,800.0 | 7,485,288.0 | 747,512.0 | 90.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,807,600.0 | 1,060,800.0 | 746,800.0 | 58.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,425,200.0 | 6,424,488.0 | 712.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 77,889,800.0 | 82,022,366.2 | -4,132,566.2 | 105.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,252,100.0 | 72,384,666.2 | -4,132,566.2 | 106.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,637,700.0 | 9,637,700.0 | 0.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 61,788,600.0 | 56,676,960.0 | 5,111,640.0 | 91.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 61,788,600.0 | 56,676,960.0 | 5,111,640.0 | 91.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 45,083,200.0 | 39,972,870.0 | 5,110,330.0 | 88.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,705,400.0 | 16,704,090.0 | 1,310.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,319,340,000.0 | 1,226,000,012.6 | 93,339,987.4 | 92.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,099,304,300.00 | 1,099,304,300.00 | 0.0 | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,099,304,300.00 | 1,099,304,300.00 | 0.0 | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 122,440,400.0 | 121,814,912.6 | 625,487.4 | 99.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 122,440,400.0 | 121,814,912.6 | 625,487.4 | 99.5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 97,595,300.0 | 4,880,800.0 | 92,714,500.0 | 5.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,179,900.00 | 4,880,800.0 | -3,700,900.0 | 413.7 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 96,415,400.00 | 00.0 | 96,415,400.0 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.0 | 96,415,450.0 | -96,415,450.0 | 0.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.0 | 74,216,560.7 | -74,216,560.7 | 0.0 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 01.0 | 01.0 | 0.0 | 100.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.0 | 01.0 | 0.0 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.0 | 01.0 | 0.0 | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 49.0 | 19.0 | 30.0 | 38.8 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.0 | 03.0 | 0.0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 29.0 | 29.0 | 0.0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17.0 | 17.0 | 0.0 | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 403.0 | 403.0 | 0.0 | 100.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 403.0 | 403.0 | 0.0 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, "Хүний хөгжлийг хангахуйц төрийн үйлчилгээний орчинг сайжруулж боловсролын үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэн, стандарт, хангалтыг дээшлүүлэх" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба, үйлчилгээний алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 49 орон тоотой, 403 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол,шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 548,967,8 мянган төгрөгөөр буюу 20.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 96,415.4 | 74,216.6 | -22,198.9 |
| Авлага | 2,327.8 | 10,030.7 | 7,702.9 |
| Урьдчилгаа тооцоо | 5,150.0 | - | -5,150.0 |
| Бараа материал | 113,289.3 | 132,748.1 | 19,458.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,497,620.8 | 3,015,989.2 | 518,368.5 |
| хуримтлагдсан элэгдэл | (537,164.2) | (506,377.7) | 30,786.5 |
| **Нийт хөрөнгө** | **2,177,639.1** | **2,726,606.9** | 548,967.8 |
| Өр төлбөр | 90.0 | 7,528.6 | 7,348.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **2,177,549.1** | **2,719,168.3** | 541,619.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,177,639.1** | **2,726,606.9** | 548,967.8 |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант онд оны эхэнд 96,415.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 74,216.6 мянган төгрөгийн өмнөх оноос 22,198.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлан онд авлага 7.702.9 мянган төгрөгөөр өмнөх оноос нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тооцож илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл төсвийн хөрөнгөөр 133,832.1 мянга, Боловсрол Шинжлэх ухааны газраас 8,024.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг шилжүүлэн авсантай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 19,458.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нөхөн хангалтын зардлаас 39,848.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан, Боловсролын ерөнхий газраас 115,850.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 513,581.7 мянган төгрөгийн дотуур байрны их засврын ажлыг хүлээн авч хөрөнгийг капиталжуулсантай холбоотой үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 16/49 дугаар тогтоолоор 150,911.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Өглөгийн данс 7,528.1 мянган төгрөг болж 7438,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд албан хаагчдаас суутган тооцсон ХХОАТ-ыг төлөөгүй байгаа гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээ данс өмнөх оноос 18,850.4 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 541,619.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,719,264.4 мянган төгрөг болсон тайлант үеийн үр дүнгийн зардлаар нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,197,396.3 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 1,197,396.3 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 196,820.2 мянган төгрөгөөр буурч 1,000,576.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тайлант онд төсөвт 6 удаа тодотгол хийж тодотголоор 1,221,119.2 мянган төгрөг болгож 220,543.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1,319,340.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,248,516.4 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 74,216.6 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна. Дансны үлдэгдлийг зардлаар нь үзвэл цалин , нийгмийн даатгал, дотуур байрны хоолны зардлын үлдэгдэл 60,808.8 буюу 81,9 хувийг эзэлж байна

Орон нутгийн төсвөөс анх батлагдсан төсөв 122,440.4 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.4 хувь буюу 625.5 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 2,594.60 | 2,594.60 | 0.00 | 100% |
| 2 | 80312 Сургалт семинар | 1,315.10 | 1,300.00 | 15.10 | 99% |
| 3 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 2,604.40 | 2,604.40 | 0.00 | 100% |
| 4 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 45,083.20 | 39,372.87 | 5,710.33 | 87% |
| 5 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 93,754.10 | 87,456.61 | 6,297.49 | 89% |
| 6 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 33,708.50 | 33,665.00 | 43.50 | 100% |
| 7 | 81823 Боловсролын байгууллагын багш | 6,498.00 | 6,490.20 | 7.80 | 100% |
| 8 | 81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 16,905.00 | 14,065.29 | 2,839.71 | 83% |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 813,705.10 | 765,158.75 | 48,546.35 | 94% |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 178,924.00 | 172,933.00 | 5,991.00 | 97% |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээс | 1,807.60 | 1,060.80 | 746.80 | 59% |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 122,440.40 | 121,814.91 | 625.49 | 99% |
| ДҮН | | 1,319,340.00 | 1,248,516.44 | 70,823.56 | 94% |

Эх сурвалж:2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 45,083.2 мянган төгрөг, дотуур байрны хоол 63,061.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын аргаар “”Ээлгранд” ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 97,494.6 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 33,665.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 29-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал М.Золзаяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Үүрцайх нар зурж, нярваар Л.Жигжид нар ажиллажээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 зугаар улирлын нийт зардлын 847,233.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,472.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 6,354.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант оны эцэст Үдийн хоол хөтөлбөрийн хүнсний материалын 3,791.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гаргаж хүнсний материалыг нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.6 заалтаас бусад хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,115,459.9 мянган төгрөгийн 56 гүйлгээ, зарлагын 236,722.9 мянган төгрөгийн 87 гүйлгээ мэдээлсэн. Орлогын 158,691.2 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, 35,869.4 мянган төгрөгийн 9 шийдвэрийг мэдээлээгүй, нийт 106 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн Энэ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”; 6.4.8.“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй.*

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, 6,099.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 1 албан шаардлага, 2,192.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 6099.4 | 1 | 6099.4 | 100 |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 2192.7 | 2 | 2192.7 | 100 |
| Нийт дүн | 4 | 8,292.10 | 3 | 8,292.10 | 100 |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.06.25-ны өдрийн 32 дугаар албан бичиг*

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.30-ны өдөр 32 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн акт, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 539,205.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 530,772.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 4,581.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 669.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, нийцлийн аудит буюу шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3182.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг төсөв захирагчид хүргүүлэв.

### 5.1 Залруулга

1. Тайлант хугацааны нийгмийн даатгалд илүү төлсөн 10030.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд 10321.4 мянган төгрөгөөр буруу тусгаж 290.8 мянган төгрөгийг илүү тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх; 15 дугаар зүйлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийв.

2. Тайлант хугацааны ХХОАТ-ыг 7348.6 мянган төгрөгийг өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх; 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3.бүх өр төлбөр; 15 дугаар зүйлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна; заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийв.

3. Өмнөх оны цалингийн урьдчилгааны авлага 5150.0 мянган төгрөгийн авлага барагдсан байхад санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх; 15 дугаар зүйлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийв.

4. Сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны их засварын ажлыг санхүүгийн тайланд сайжруулалтаар бүртгээгүй шинээр хөрөнгө үүсгэж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх гэсэн заалтыг зөрчсөн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийв.

5. Аймгийн ИТХ-аас олгосон 3750.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй, 573.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг цалин урамшууллын зардалд, 77.5 листийг үндсэн цалингийн зардалд хаалгаж гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх; 15 дугаар зүйлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд залруулга хийв.

**5.2 Албан шаардлага**

Тайлант хугацаанд 2 албан хаагчийн 669.4 төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,1 дэх ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."гэсэн заалтуудыг гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

**5.3 Төлбөрийн акт**

**Илрүүлэлт:**

1. Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/136 тоот захирамжаар 25 хувийн ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургуулийн захиралд давхардуулан олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын "4.11.Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн захирагчаар 279.5 мянган төгрөгийг төлүүлж, төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Мэдээлэл технологийн зардлаас сургуулийн захирал, нягтлан бодогч, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, тогооч, бичиг хэргийн ажилтанд сар бүр 510.0 мянган төгрөгийн дата хэрэглээг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Шийдвэрлэсэн нь:** Зориулалт бусаар зарцуулсан 550.0 мянган төгрөгийн төсвийн захирагчаар төлүүлж, орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант хугацааны хүүхдийн үдийн цайны зардал 3791.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Засгийн газрын "Хоолны норматив тогтоох тухай" 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 4 дэх заалт "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх", гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хэмнэлтээс үлдсэн 3791.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.4 Зөвлөмж

**Илрүүлэлт:**

Ажлын гүйцэтгэл ур чадварыг үнэлсэн анхан шатны баримтгүй, тус сургуулийн захирлын 2023.12.14-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар 12 дугаар сард нэр бүхий 5 багшид ур чадварын нэмэгдэл 30-70% тооцож 3182.5 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар 5.1.4.үнэн зөв байх; 13 дугаар зүйлийн 3.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгөв.

**Нийцлийн аудиттай холбоотой асуудал**

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

***Илрүүлэлт:*** Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан орлогын 158,691.2 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 35,869.4 мянган төгрөгийн 9 шийдвэрийг мэдээлээгүй, нийт 106 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл технологийн зардлаас сургуулийн захирал, нягтлан бодогч, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, тогооч, бичиг хэргийн ажилтанд сар бүр 510.0 мянган төгрөгийн дата хэрэглээг төлсөн | 1 | 510 | 1 | 510 | | | | |
| Тайлант хугацааны хүүхдийн үдийн цайны зардал 3791.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. | 1 | 3791.8 | 1 | 3791.8 | | | | |
| Сумын Засаг даргын 2023 оны 12 сарын 14 ны өдрийн А/136 тоот захирамжаар 25 хувийн ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. | 1 | 279.5 | 1 | 279.5 | | | | |
| Тайлант хугацаанд 2 албан хаагчийн 669.4 төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн | 1 | 669.4 | | | 1 | 669.4 | | |
| Ажлын гүйцэтгэл ур чадварыг үнэлсэн анхан шатны баримтгүй, тус сургуулийн захирлын 2023.12.14-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар 12 дугаар сард нэр бүхий 5 багшид ур чадварын нэмэгдэл 30-70% тооцож 3182.5 мянган төгрөг олгосон. | 1 | 3182.5 | | | | | 1 | 3182.5 |
| Нийт дүн | 5 | 8433.2 | 3 | 4581.3 | 1 | 669.4 | 1 | 3182.5 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой | | | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан орлогын 158,691.2 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 35,869.4 мянган төгрөгийн 9 шийдвэрийг мэдээлээгүй, нийт 106 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 52/14210573/БНА/2024 147/НА-СТА-ЛШЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хэрэглээний зардлаас багшаас бусад ажилтанд 510,000.00 төгрөгийн дата эрх өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар 2.4 дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний зардлыг нийт үндсэн багш,бүлгийн болон хөгжим биеийн тамирын багшийн нийт тоогоор тооцно. гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 510,000.00 /Таван зуун арван мянган / төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
1. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар

5050099

сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 57/14210573/БНА/2024 /147/НА-СТА-ПМУЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст Үдийн хоол хөтөлбөрийн хоолны материалын 3,791,800.00 төгрөгийн нөөц үлдэгдэлтэй байгаа нь 2022 оны аудитаар үдийн цай хөтөлбөрийн дансны үлдэгдэл, хэмнэгдсэн төсвийн талаар Боловсролын газрын хэмжээнд дараагийн аудитаар анхаарах асуудлаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Засгийн газрын "Хоолны норматив тогтоох тухай" 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 4 дэх заалт "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх", гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үдийн хоол хөтөлбөрийн материалын үлдэгдэл 3,791,800.00 /Гурван сая

5050114

долоон зуун ерэн нэгэн мянга найман зуун/ төгрөгийг 2024 оны төсвөөс төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 23 өдөр Дугаар 67/142105 13/БНН/2024/47/-НА-СТА-ТШ3 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/136 тоот захирамжаар сургуулийн захиралд 25 хувийн ажлын үр дүнгийн урамшуулал 279,500.00 төгрөг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харъяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалт Үнэ зөв бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр дүнгийн урамшуулалд олгосон 279,500.00 /Хоёр зуун далан есөн мянга таван зуун / төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

5050145

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

6417143544
БЮ20067 9007423

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 92/14210513/БНА/2024 Номгон
173/НА-СТА-ТШЗ.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд нэр бүхий хоёр ажилтны цалинг 669,400.00 дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1,1 дэх ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд ногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж хугацаанд нь төлөх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1” Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”гэсэн заалтуудыг гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд хоёр албан хаагчийн 669,400.0 /Зургаан зуун жаран есөн мянга дөрвөн зуун/ төгрөгийн цалинг нөхөн мэдээлж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 83,675.00 төгрөгийг Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн дансанд төлж барагдуулах.

5040170

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав[1].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О. МАНДАХ

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 2 сарын 23 өдөр Дугаар 95/1421057З/БНА/2024 Номгон
47/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим сайтад хуулийн 6.4.5-д заасан орлогын 158,691.2 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, хуулийн 6.4.8-д заасан 35,869.4 мянган төгрөгийн 9 шийдвэрийн мэдээлээгүй нийт 106 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1].

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5040179

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг хүрээнд Эрдэнэцогт сумын ерөнхий боловсролын захирал М.Золзаяа, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

---

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно